



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/07

Мандалговь

Ажил, албан тушаалын зэрэглэл, цалин,
нэмэгдлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3, 10 дугаар хавсралт, 2024 оны “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, аймгийн Засаг даргын 2024 оны А/171 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалин, нэмэгдлийг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2. Албан хаагчдын албан тушаалын сарын үндсэн цалин, зарим нэмэгдлийг хавсралтад заасны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс, орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, ажилласан хугацааны нэмэгдлийг цаашид хууль, журмын холбогдох заалтын дагуу тухай бүр нэмэгдүүлэн тус тус тооцож олгохыг нягтлан бодогч Э Саранзаяад зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ХУЛАН



482412023